



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Улсын Их Хурлын саналын дагуу хийсэн аудитын тайлан

БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГ ШИНЭЧЛЭХ ШААРДЛАГАТАЙ БОЛЖЭЭ

Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын
санхүүгийн зарим үйл ажиллагаа

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>ҮАГ-ын хоёрдугаар газар</p> <p><i>Захирал</i> О.Мэндбаяр</p> <p><i>Аудитын менежер</i> Х.Баярмаа</p> <p><i>Ахлах аудитор</i> С.Сэрчхорол</p> <p><i>Аудитор</i> Ц.Цэрэнхүү З.Цээнээ Б.Долгорсүрэн</p> <p><i>Шинжээч</i> Д.Болормаа Д.Баттулга</p> <p>2007 оны 11 дүгээр сар</p> <p><i>Уг тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:</i></p> <p><u>www.mnao.pmis.gov.mn</u></p> <p><i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533, 263755 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i></p> <p>ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i></p>	<p>Товчилсон үгсийн жагсаалт 3</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4</p> <p>Бүлэг 1 Орлогыг хэт доогуур төлөвлөж, өөрт үлдэх хөрөнгийг нэмэгдүүлжээ 5</p> <ul style="list-style-type: none"> • Төсвийн орлогыг хугацаа саатуулж төвлөрүүлжээ 5 • Бүтээгдэхүүн хуваах гэрээ нь мөрдөж байгаа хуулиудтай зөрчилдөж байна 7 • Сургалтын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байна 10 <p>Бүлэг 2 Яам хууль зөрчин агентлагийн төсвөөс 1.5 тэрбум төгрөг зарцуулжээ 11</p> <ul style="list-style-type: none"> • Яам харьяа агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлаагүй байна 11 • Зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлжээ 13 • Шагнал урамшууллыг хавтгайруулан олгожээ 15 • Яам хууль зөрчин агентлагийн төсвөөс 1.5 тэрбум төгрөг зарцуулжээ 15 • Их засварын зардлын төсвийг хэтрүүлжээ 17 • Батлагдсан төсөвгүйгээр автомашин худалдан авчээ 17 • Зөвлөмж 19
--	---

• Холбогдох байгууллагын санал	20
• Тайлбар	25
• Хавсралт	28

Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ЗТАЖЯ	Зам тээвэр, аялал жуулчлалын яам
ГХЯ	Гадаад хэргийн яам
ҮХС	Үйлдвэр, худалдааны сайд
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МГТТ	Монголын Газрын тосны товчоо
ААНОАТТХ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
ГТХЭГ	Газрын тосны хэрэг эрхлэх газар
ЗГАЭЗБТХ	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо болон Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийв.

АМГТХЭГ-ын санхүүгийн зарим үйл ажиллагааг шалгаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитаар дараахь асуудлыг авч үзэв. Үүнд:

- Орлогыг хуулийн дагуу төвлөрүүлсэн эсэх;
- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх;
- Орон нутгийн төсөвт зохих төлбөр, хураамжийг төвлөрүүлж байгаа эсэх;

Аудитад дор дурдсан арга зүйг ашиглалаа. Үүнд:

- АМГТХЭГ-ын санхүүгийн үйл ажиллагаатай танилцах;
- ҮХЯ болон АМГТХЭГ-ын холбогдох ажилтнуудаас судалгаа, тодруулга авах;
- Дорнод аймгийн Тамсаг, Халхгол суманд газрын тосны хайгуул, олборлолт хийж байгаа “Петро-Чайна-ДаЧин-Тамсаг” ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээтэй танилцах;
- АМГТХЭГ-ын хөрөнгө оруулалтын үр дүнг шалгах;
- АМГТХЭГ-ын төсвийн гүйцэтгэлд тавих дотоодын хяналтыг шалгах;

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ҮХЯ-ны санхүү, эдийн засгийн хэлтэс болон АМГТХЭГ хамрагдлаа.

Бүлэг 1


ОРЛОГЫГ ХЭТ ДООГУУР ТӨЛӨВЛӨЖ, ӨӨРТ ҮЛДЭХ ХӨРӨНГИЙГ НЭМЭГДҮҮЛЖЭЭ

1.1 Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 249 дүгээр тогтоолоор Ашигт малтмалын хэрэг эрхлэх газар, Газрын тосны хэрэг эрхлэх газрыг нэгтгэн Үйлдвэр худалдааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрыг байгуулжээ.

Төсвийн орлогыг хугацаа саатуулж төвлөрүүлжээ

1.2 АМГТХЭГ-т 2005 онд 9'019.2 сая, 2006 онд 15'038.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас 2005 онд 23'685.5 сая, 2006 онд 32'987.5 сая төгрөг төвлөрүүлжээ.

График 1. 2005, 2006 оны орлогын бүтэц



1.3 2007 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 32'258.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлсний лицензийн төлбөрөөс 63.1% буюу 20'362.6 сая төгрөгийн, газрын тосны экспортоос 16.4% буюу 5'305.2 сая төгрөгийн, геологи хайгуулын зардлын нөхөн төлбөрөөс 7.5% буюу 2'428.0 сая төгрөгийн, үлдэх 13.0 хувь буюу 4'163.3 сая төгрөг нь үндсэн үйл ажиллагааны болон бусад орлого байна.

1.4 АМГТХЭГ-ын орлогын дийлэнх хэсгийг лицензийн төлбөрийн орлого эзэлдэг бөгөөд газрын тосны экспортын орлого 2006 оноос нэмэгдэж байна.

1.5 Сангийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын 2005 оны 15/11 дүгээр тушаалаар АМГТХЭГ-ын санхүүжилтийн зарчмыг баталж, ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лицензийн төлбөр болон улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн геологи, хайгуулын ажлын нөхөн төлбөр, газрын тосны экспортын орлогын Засгийн газарт ногдох хэсгийн төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын нийлбэр дүнгээс 10.8 хувь, бусад үйлчилгээний орлогыг тус газрын санхүүжилтийн эх үүсвэрт үлдээх, тухайн жилийн байгууллагын мэдэлд үлдэх орлогоос батлагдсан зардлын хэмжээнд зарцуулж, давсан орлогын 50 хувийг

улсын төсөвт төвлөрүүлэхээр тогтсон байна. Энэхүү журмыг 2005, 2006 оны санхүүгийн үр дүнг тооцоход мөрджээ.

1.6 АМГТХЭГ 2005 онд 21'208.8 сая төгрөг, 2006 онд 20'716.7 сая төгрөг, 2007 оны 9 сарын байдлаар 35'671.2 сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 1.1. АМГТХЭГ-ын орлого, түүний хуваарилалт

(сая
төгрөгөөр)

№	Үзүүлэлтүүд	Тайлангийн хугацаа		
		2005 он	2006 он	2007.09.30
1.1	Орлогын төлөвлөгөө	9'019.2	15'038.0	17'503.5
1.2	Орлогын гүйцэтгэл	22'299.9	29'676.6	28'095.6
2	Батлагдсан зардал	1'072.3	1'098.8	1'420.5
2.1	Лицензийн төлбөр	18'926.7	21'467.5	20'362,4
2.2	Газрын тосны экспорт	1'881.7	5'498.0	5'305.2
2.3	Геологи хайгуулын зардлын нөхөн төлбөр	1'491.5	2'711.1	2'428.0
3	Төсөвт төвлөрүүлбэл зохих 89.2%	19'891.5	26'471.5	27'794.8
4	АМГТХЭГ-ын санхүүжилтэд 10.8%	2'408.4	3'205.1	300.8
5	Үйлчилгээний болон бусад орлого	1'385.6	3'310.9	4'163.3
6	АМГТХЭГ-т үлдэх нийт орлого	3'794.0	6'516.0	4'464.1
7.1	Зардлаас давсан орлого	2'721.7	5'417.2	3'043.6
7.2	Төсөвт төвлөрүүлбэл зохих 50 %	1'360.8	2'708.6	
8.1	Төсөвт төвлөрүүлбэл зохих нийт орлого	21'252.4	29'180.1	17'503.5
8.2	Төсөвт төлсөн	21'208.8	20'716.7	35'671.2
8.3	Зөрүү	43.6	8'463.4	18'167.7
9	Байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр	2'433.1	3'807.4	4'464.1

1.7 Хүснэгтээс харахад орлогыг хэт доогуур төлөвлөснөөс 2005 онд 2.4, 2006 онд 1.9, 2007 оны 9 сарын байдлаар 1.6 дахин давж биелж, улмаар тус газарт үлдэх орлогын хэмжээ ихэсчээ. Цаашид сүүлийн гурван жилийн орлогын жигнэсэн дунджаар төлөвлөж байх нь зүйтэй байна.

1.8 ҮХС-ын 2006 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн "Данс төвлөрүүлэх" тухай 42 дугаар тушаалаар тус газрын төсвийн орлогын болон үйлчилгээний орлогын бүх дансыг яамны санхүү, эдийн засгийн хэлтэст татан төвлөрүүлж, мөн оны 92 дугаар тушаалаар яамны төрийн нарийн бичгийн дарга Б.Нямсүрэн, санхүүгийн хэлтсийн дарга Д.Алтантөгс нарт захиран зарцуулах эрхийг олгожээ.

1.9 ҮХЯ санхүүжилтийн дээрх зарчмыг үндэслэн байгууллагад үлдэх орлогын 10.8 хувь болон батлагдсан төсвөөс давсан орлогын 50 хувийг тооцож АМГТХЭГ-ын төрийн сан дахь дансанд шилжүүлж санхүүжүүлж байжээ.

1.10 ҮХЯ тус агентлагийн хөрөнгийн зарцуулалтын бүх эрхийг авсан боловч төсөвт төвлөрүүлэх орлогыг саатуулж 2006 онд улсын төсөвт 8'463.4 сая төгрөгийг дутуу төлсөн бөгөөд 2007 оны эхэнд гүйцээн төвлөрүүлжээ.

1.11 Сангийн болон Үйлдвэр, худалдааны сайд нар 2007 оны 2 дугаар сарын 7-ны өдөр “Хуулийн хэрэгжилтийг хангах тухай” 34/37 дугаар тушаал гаргаж, ҮХЯ, АМГТХЭГ-ын улсын төсвийн болон үйлчилгээний орлогын арилжааны банкинд байршиж буй харилцах дансны үлдэгдлийг 2007 оны 2 дугаар сарын 10-ны дотор Улсын төсвийн холбогдох татварын орлогын дансанд төвлөрүүлж, төсвийн болон үйлчилгээний орлогын дансыг дээрх арилжааны банкинд “Тэг” үлдэгдэлтэй дансны хэлбэрээр байршуулах талаар Сангийн яам, ҮХЯ, Арилжааны банк хооронд гурвалсан гэрээ байгуулан ажиллахыг ҮХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б.Нямсүрэн, АМГТХЭГ-ын дарга Л.Болд нарт үүрэг болгожээ.

1.12 Дээрх тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын 2005 оны 15/11 дүгээр, Үйлдвэр, худалдааны сайдын 2006 оны 92 дугаар тушаалыг хүчингүй болгосон байна.

1.13 ҮХЯ тушаалд заасан хугацаанд дансны гүйлгээг хаагаагүй бөгөөд 2007 оны 3 дугаар сарын 2-нд “Монгол шуудан” банкин дахь төсвийн орлогын 2, үйлчилгээний орлогын 2, “Улаанбаатар” банкин дахь төсвийн орлогын 2, үйлчилгээний орлогын 2, бүгд 8 дансыг хаан “Тэг” үлдэгдэлтэй дансны хэлбэрт шилжүүлжээ.

1.14 Үндсэн үйл ажиллагааны орлогод кадастрын үйлчилгээ, газрын тосны үйл ажиллагаа, геологийн ажлын тайлангийн орлого болон бусад орлого багтдаг бөгөөд орлогын хэмжээ жил ирэх тусам өсөн нэмэгдэж иржээ. Үүнд, 2005 онд 1'385.6 сая, 2006 онд 3'310.9 сая, 2007 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 4'163.3 сая төгрөгийн орлого орсон байна. Энэ нь тус газрын санхүүжилтийн үндсэн эх үүсвэр болдог байна.

1.15 Тус агентлаг орлогын төлөвлөгөөг хэт доогуур батлуулж, улмаар өөрт үлдэх орлогыг ийнхүү жил бүр нэмэгдүүлж, үр ашиггүй, үрэлгэн зарцуулж байгааг цэгцлэх шаардлагатай болжээ.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ нь мөрдөж буй хуулиудтай зөрчилдөж байна



1.16 Өнөөдрийн байдлаар Монгол Улсын нутаг дэвсгэрт 5 компани долоон талбайд БХГ байгуулж, газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж байна. БХГ-ний дагуу газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй компаниудын олборлосон газрын тосны экспортын орлогын төвлөрүүлэлтийг 2005, 2006 он, 2007 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар харуулав. (Хавсралт № 1)

1.17 Газрын тосны экспортын орлого 2005 онд 1'789.4 мянга, 2006 онд 4'033.7 мянга, 2007 оны 9 сарын 30-ний байдлаар 6'670.7 мянган ам.доллар тус тус төвлөрчээ.

1.18 1993-1995 онд Газрын тосны товчоо (хуучин нэрээр) болон Австралийн Команд петролиум лимитэд, Монголын Цагаан шонхор ойл корпораци, Соко

тамсаг монголиа инк нарын хооронд БХГ байгуулжээ. Газрын тосны хуулийг хэрэгжүүлэх журмын хавсралтаар газрын түрээсийн төлбөр болон захиргааны шимтгэлийн тарифыг тогтоож өгчээ.

1.19 АНУ-ын “СОКО Интернейшнл” компани 2005 оны 8 дугаар сард БНХАУ-ын “Петро-Чайна-ДаЧин-Тамсаг” ХХК-д эрхээ шилжүүлж “Бүтээгдэхүүн хуваах гэрээ” болон Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журамд заасны дагуу талбай тутамд 100.0 мянган ам.доллар буюу нийт 300.0 мянган ам.долларыг АМГТХЭГ-т төлжээ.

1.20 Петро Чайна Дачин Тамсаг ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ өнөөгийн хууль, эрх зүйн орчинтой зөрчилдөж байгаагаас дахин авч үзэх шаардлагатай байна. Тухайлбал:

- ✚ Нэгдсэн төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн “Аймаг нийслэлийн төсвийн татварын орлого дараахь орлогоос бүрдэнэ” гэсэн заалтын 1.3-т “Газрын төлбөр”, мөн Татварын ерөнхий хуулийн “Орон нутгийн татвар” гэсэн заалтын 17.14-т “Газрын төлбөр” гэж тус тус заасан байна.Өөрөөр хэлбэл, Нэгдсэн төсвийн тухай болон Татварын ерөнхий хуульд газрын төлбөрийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж байхаар заажээ.
- ✚ Гэтэл БХГ-нд олборлосон газрын тосыг бүтээгдэхүүн хуваах зарчмын дагуу хувааж, төлбөрийг “Газрын тосны товчоонд төвлөрүүлнэ” гэж заасан нь дээрх хуулиудтай зөрчилдөж байна.
- ✚ ЗГ-ын 1991 оны 204 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 19 дүгээр зүйлийн 3-т “Гэрээлэгчийн төлөх бусад татварыг хэлэлцээр байгуулахад дагаж мөрдөж байгаа болон хэлэлцээр хүчин төгөлдөр байх хугацаанд цаашид батлагдах аливаа хууль тогтоомжид зааснаар ногдуулна” гэсэн заалтыг үндэслэн БХГ-г шинэчлэн баталсан хуулийн дагуу өөрчлөх нь зүйтэй байна.
- ✚ Үүний улмаас орон нутгийн төсөвт төвлөрвөл зохих орлого дутуу төвлөрч, маргаан үүсэх нөхцөл бүрджээ. Дорнод аймгийн Матад, Халх гол сумын нутагт газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа “Петро-Чайна-ДаЧин-Тамсаг” ХХК орон нутгийн төсөвт дараахь орлогыг төвлөрүүлжээ.

(мянган төгрөгөөр)

№	Татварын төрөл	2005 он	2006 он	2007 он
1	Ус, рашаан ашигласны татвар	450.0	16'048.5	56'620.4
2	Тээврийн хэрэгслийн татвар	-	-	495.0
	Нийт дүн	450.0	16'048.5	57'115.4

- ✚ Газрын тосны тухай хуулийн 6-д заасан “...байгалийн нөөц баялаг, газар, хэвлий болон түүний хүрээлэн байгаа орчинд хохирол учруулахгүй байх, ашигласан талбайг сэргээх” талаар БХГ-нд тусгаагүй байна.
- ✚ Байгалийн нөхөн сэргээгдэшгүй баялаг ашигласны төлбөрийг БХГ-нд шинэчлэн тусгаж өгөөгүйгээс 2005-2007 онд “Петро-Чайна-ДаЧин-

Тамсаг” ХХК-иас 2’496.6 мянган ам.долларын төлбөр авах боломжийг алджээ.

- ✚ БХГ-нд “Хүн авч ажиллуулахдаа юуны өмнө зохих ёсны мэргэжилтэй монголын иргэдийг сонгож авахыг урьтал болгоно. Гэхдээ гэрээлэгч гол албан тушаалд өөрийн ажиллагсадыг ажиллуулах эрхтэй. Монголын иргэдийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу МГТТ-гоор дамжуулан цалинжуулна” гэж заажээ.
- ✚ Монгол Улсын Засгийн газар Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 7.3-т заасныг үндэслэн газрын тосны хайгуул, олборлолт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагааг гүйцэтгэх гадаадын ажилчдын квотыг хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан газрын тос, шатдаг хийн хайгуулын ажилчдын гадаадын ажиллах хүч 90, өөрийн орны ажиллах хүч 10 хүртэл хувь байхаар жил бүр шинэчлэн баталж байжээ.
- ✚ 2007 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн Засгийн газрын 58 дугаар тогтоолоор”2007 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувь”-ийг, 59 дүгээр тогтоолоор аж ахуйн нэгж, байгууллагуудад ажиллах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний тоог баталж, Дорнод аймгийн Тамсаг, Дорноговь аймгийн Зүүнбаянгийн сав газарт газрын тосны хайгуул, олборлолт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Петро-Чайна-ДаЧин-Тамсаг” ХХК –ийн 3620 ажилтан, “Доншен” ХХК-ийн инженер техникийн 480 ажилтанд 2007 онд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг олгож, мөн хугацаанд ажлын байрны төлбөрөөс чөлөөлжээ.
- ✚ Дорнод аймгийн Матад, Халх гол сумын нутагт газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Петро-Чайна-ДаЧин-Тамсаг” ХХК-д 2005 онд 162, 2006 онд 1435, 2007 оны 9 дүгээр сарын байдлаар 3510 хүн ажиллаж байна.

1.21 1991 онд батлагдсан Газрын тосны тухай хуулийн 9.2-ын “Газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж байгаа гэрээлэгчид Монгол Улсын хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр татвар ногдуулна” гэсэн заалт, 1992, 2001, 2006 онд батлагдсан ААНОАТ-ын тухай хуулийн 18.1.2-т “Газрын тосны салбарт БХГ-ний дагуу тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн өөрт нь ногдох бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлогыг албан татвараас чөлөөлнө” гэсэн заалт хоорондоо зөрчилдөж байна.

1.22 Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаас 2006 оноос өмнө газрын тосны салбарт хайгуул, олборлолтын чиглэлээр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай асуудлыг судалж, шийдвэрлэх талаар санал боловсруулахыг СЯ, ХЗДХЯ, ГХЯ, ҮХЯ, ЗТАЖЯ-д үүрэг болгосны дагуу мөн оны 6 дугаар сарын 5-нд ажлын хэсэг байгуулагджээ.

1.23 Тус ажлын хэсгээс 2007 оны 10 дугаар 10-нд Засгийн газрын хуралдаанд дээрх асуудлыг танилцуулсан бөгөөд Засгийн газрын хуралдааны тэмдэглэлээр Үйлдвэр худалдааны болон Сангийн сайдад уг асуудлыг дахин боловсруулахыг даалгасан байна.

1.24 Энэ бүх байдлаас үзэхэд 1993-2006 онд газрын тосны салбарт хайгуул, олборлолтын чиглэлээр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг одоо мөрдөж буй хуулиудад нийцүүлэн шинэчлэх шаардлагатай нь харагдаж байна.

Сургалтын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байна



1.25 1993, 1995 онд “СОКО Интернешнл” ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний 6.1-д МГТТ-ны ерөнхий захирлын томилсон буюу заасан мэргэжлийн дагуу нэг ажилтны замын зардал, сургалт, амьжиргааны зардлыг төлөхөөр заажээ.

1.26 Сургалтын сангийн хөрөнгийг ҮХС-ын 2003 оны 7 дугаар тушаалаар батлагдсан “Сургалтын дансны хөрөнгийг зарцуулах журам”-ыг үндэслэн зарцуулж байгаад АМГТХЭГ-ын даргын 2007 оны 120 дугаар

тушаалаар батлагдсан “Сургалтын журам”-ын дагуу сургалтын санг бүрдүүлэн зарцуулж байна.

1.27 БХГ-нд “Сургалтын урамшуулал” дансанд “Петро-Чайна-ДаЧин-Тамсаг” ХХК жилд нэг талбайд 75000 ам.доллар буюу нийт 225000 ам.доллар, “Доншен” ХХК нэг талбайд 60000 ам.доллар төвлөрүүлэхээр тусгасан бөгөөд 2005-2007 онд дээрх хоёр компаниас нийт 855000 ам.доллар төвлөрчээ.

1.28 2006 онд БХГ шинээр байгуулсан компаниудаас сургалтын урамшуулалд “Петро-Матад” ХХК 20000 ам.доллар, “Panosian Petroleum INC N” (Шамон) 50000 ам.доллар, “Голден Сий Петролеум” ХХК 80000 ам.доллар оруулжээ.

1.29 АМГТХЭГ богино, дунд, урт хугацааны сургалтад хамрагдах ажилтан болон ажилтнуудын хүүхдүүдийг даргын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэж, агентлагийн даргын тушаалыг үндэслэн сургалтын санг захиран зарцуулдаг боловч яамнаас тодорхой хэмжээгээр сургалтын үйл ажиллагаанд оролцож иржээ.

1.30 АМГТХЭГ-ын зардлаар гадаадын их, дээд сургуульд суралцаж байгаа оюутнуудын судалгаанаас үзэхэд газрын тосны болон ашигт малтмалын мэргэжлийн чиглэлээр бус өөр мэргэжлийн хүмүүсийг сургалтад хамруулж зардлыг төлж байна. Тухайлбал, Д.Оюунсанаа ХБНГУ-ын Дредзен хотын Техникийн Их Сургуульд социологич, Б.Номин Мюнстр хотод англи хэл, түүх судлал, Ө.Хангайхүү Карлсын Их сургуулийн мэдээлэл зүй судлал, Э.Солонго Москвагийн ОУХДС-ийн худалдааны эрх зүйч мэргэжлээр суралцаж байна.

1.31 Түүнчлэн ҮХЯ-ны санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Д.Алтантөгсөд Вашингтон хотын Белливио Комюнити коллежид олон улсын бизнесийн програмын мэргэжлээр суралцуулах талаар ҮХС тушаал гаргаснаар 11000 ам.долларыг 2007 оны 6 дугаар сарын 14-нд сургуулийн дансанд шилжүүлж, 5000 ам.долларыг 7 дугаар сарын 4-нд Алтантөгсийн Виза картад шилжүүлсэн

боловч одоо хүртэл суралцах талаар гэрээ байгуулаагүй, сургуульдаа суралцаагүй байна.

1.32 ҮХЯамны дэд сайд Я.Содбаатарын хүсэлтээр тус яамны хэвлэл, мэдээллийн ажилтан Н.Туяагэрэлийн охин Т.Золбоотод АМГТХЭГ-ын даргын 2007 оны 197 дугаар тушаалаар БНСУ-ын Сөүлын Их сургуульд суралцах сургалтын зардалд зориулан 4000 ам.долларыг нэг удаагийн тусламж болгон хувийн харилцах дансанд шилжүүлсэн нь Төрийн албаны тухай хууль болон ҮХС-ын баталсан сургалтын дансны хөрөнгийг зарцуулах журмыг тус тус зөрчжээ.

1.33 Өнгөрсөн онуудад сургалтын зардлаар бэлтгэгдсэн мэргэжилтнүүдээс тухайн байгууллагад ажиллаж байгаа мэргэжилтэн цөөнгүй ч агентлагийн зардлаар боловсрол эзэмшчихээд тус газарт ажиллаагүй тохиолдол байна.Тухайлбал, 2005 онд АНУ-ын Виржинийн Их сургуулийг бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн О.Ариунзул (34877 ам.доллар)УИХ-ын гишүүний туслахаар ажиллаж, харин Д.Алтанцэцэг (21600 ам.доллар) 2006 онд БНХАУ-ын ГТИС-д суралцаж, эдийн засгийн менежмент сэдвээр мастер хамгаалсан боловч тус газар ажиллаагүй байна.

1.34 2005 онд 8000 ам.доллараар БНХАУ-аас тавилга, эд хогшил худалдан авсан, 2007 онд 3700 ам.доллараар олон улсын ашигт малтмалын зах зээлийн ханш үздэг веб сайтын төлбөр төлж, сургалтын сангийн данснаас зориулалт бусаар зарцуулжээ.

1.35 2007 онд Бразилийн "Петролиум" компанид судалгааны 7 багц материал борлуулснаас төсөвт төвлөрүүлэх 90000 ам.долларыг сургалтын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор тус дансанд төвлөрүүлсэн бөгөөд энэ данс төрийн санд бус арилжааны банкинд байршиж байна.

1.36 Цаашид сургалтын сангийн хөрөнгийг Сургалтын төрийн санд нэгтгэх нь зүйтэй байна.

Бүлэг 2

ЯАМ ХУУЛЬ ЗӨРЧИН АГЕНТЛАГИЙН ТӨСВӨӨС 1.5 ТЭРБУМ ТӨГРӨГ ЗАРЦУУЛЖЭЭ

2.1 2007 оны 3 дугаар сарын 2-ноос төсвийн болон үйлчилгээний орлогын данснууд АМГТХЭГ-т төвлөрч, эдгээр данснаас зарцуулалт хийлгүй, зөвхөн орлого төвлөрүүлж, буцаалтын гүйлгээ хийн, агентлагийн санхүүжилтийг төрийн сангийн дансанд шилжүүлэн ажиллаж байна.

Яам харъяа агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг батлаагүй байна

2.2 Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д “Агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Монгол Улсын сайд батална” гэж заасан.

2.3 АМГТХЭГ 2005 болон 2006 онд нэг, 2007 онд гурван удаа тус газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийн төслийг ҮХС-д хүргүүлсэн боловч өнөөг хүртэл батлагдаагүй байна.

2.4 АМГТХЭГ-ын зохион байгуулалтын бүтэц, орон тоог ҮХС солигдох бүрт өөрчилж иржээ. Үүнд:

- ҮХС асан С.Батболд 2005 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 174 дүгээр тушаалаар АМГТХЭГ-ын зохион байгуулалтын бүтцийг 6 газартайгаар баталж, орон тооны дээд хязгаарыг 131 хүнээр тогтоосон;
- ҮХС асан Б.Жаргалсайхан 2006 оны 46 дугаар тушаалаар АМГТХЭГ-ын зохион байгуулалтын бүтцийг 6 албатайгаар баталж, орон тооны дээд хязгаарыг 266 хүнээр тогтоосон;
- ҮХС-ын үүрэг гүйцэтгэгч Н.Баяртсайхан 2007 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 62 дугаар тушаалаар АМГТХЭГ-ын зохион байгуулалтын бүтцийг 5 газар, 1 төвтэйгээр баталж, орон тооны дээд хязгаарыг 204 хүнээр тогтоож, дээрх 46 дугаар тушаалыг хүчингүй болгосон;
- ҮХС Ц.Даваадорж 2007 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 156 дугаар тушаалаар АМГТХЭГ-ын зохион байгуулалтын бүтцийн

тухай 62 дугаар тушаалыг хүчингүй болгож, 46 дугаар тушаалыг сэргээн баталжээ.

Ингэж ойр ойрхон бүтэц зохион байгуулалт, орон тоог өөрчилсөн нь агентлагийн төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулах боломжгүй болгож байна.

Зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлжээ

2.5 АМГТХЭГ батлагдсан зардлын төсвийг 2005-2007 онд хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт 2.1 АМГТХЭГ-ын төсөв түүний гүйцэтгэл

Огноо	Батлагдсан зардлын төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт	(сая төгрөгөөр)
				Хэтрэлтийн хувь
2005	1'072.3	1'744.6	-672.3	62.7
2006	1'098.9	2'514.5	-1'415.6	128.8
2007.9.30	1'385.0	2'517.3	-1'132.3	81.8

2.6 Хэтрэлтийг зардлын зүйл бүрээр авч үзвэл 2005-2007 онд ажиллагсадтай холбогдсон зардал 377.2 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардал 1'462.0 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

2.7 АМГТХЭГ батлагдсан төсвөө 2005 онд 672.3 сая, 2006 онд 1'415.6 сая, 2007 оны эхний 9 сард 1'132.3 сая төгрөгөөр тус тус хэтрүүлжээ.

2.8 ҮХС-ын 2006 оны 46 дугаар тушаалаар агентлагийн орон тоог хоёр дахин нэмэгдүүлж, шаардагдах цалингийн зардлыг төсвийн тодотгол батлагдах хүртэл тухайн үед мөрдөгдөж байсан журмын дагуу төлөвлөгөөнөөс давсан орлогын агентлагт үлдэх хэсгээс цалинжуулахаар шийдвэрлэсэн боловч төсвийн тодотголд оруулж батлуулаагүйгээс 2006 онд ажиллагсадтай холбогдсон зардал 179.8 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

2006 оны жилийн эцсийн тайланд батлагдсан төсөвгүй бусад зардалд 70.0 сая төгрөг бүртгэжээ. Үүний 53.9 сая төгрөг нь хөрөнгийн элэгдлийн, 16.1 сая төгрөг нь урсгал зардалд бичих зардал байна.

2.14 2006 оны салбарын төвлөрсөн арга хэмжээний зардал 91.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь баяр ёслолын арга хэмжээнд ихээхэн хөрөнгө зарцуулснаас шалтгаалжээ. Тухайлбал, шинэ жилийн арга хэмжээнд 42.7 сая төгрөг, уул уурхайн салбарын 84 жилийн ойн арга хэмжээнд 12.5 сая төгрөг, геологчдын болон газрын тосны салбарын ажилчдын баярын арга хэмжээнд 20.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Шагнал урамшууллыг хавтгайруулан олгожээ

2.15 ГТХЭГ-ын даргын 2005 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан дотоод журмын 6-ын 1 дэх заалтыг үндэслэн 2006 онд нийт ажиллагсдад сар бүр тусгай (газрын) нэмэгдэлд 83.2 сая, албан хаагчдын хоол, унааны хөнгөлөлтөд 53.5 сая, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 12.8 сая, бүгд 149.5 сая төгрөг зарцуулжээ.

2.16 Газрын нэмэгдэл олгосон дээрх журам ЗГ-ын 2004 оны 42 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгох журам”-ын 3.1-д “Төсвийн ерөнхий менежер нь төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгохдоо дор дурдсан дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй байна”, ЗГ-ын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчдад шагнал, урамшил олгох журам”-ын 5-д “... төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр албан тушаалын сарын цалингийн 40 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал олгож болно...” гэсэн заалтуудыг тус тус зөрчжээ.

2.17 УИХ болон ҮХЯ, бусад байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлтийг үндэслэн гадны байгууллага, хүмүүсийн албан томилолтын зардалд 109.2 сая төгрөгийг батлагдсан төлөвлөгөөгүй зарцуулжээ. Мөн 2005 онд ҮХЯ-ны нэр бүхий хүмүүст албан томилолтын зардалд 14.5 сая төгрөгийг урьдчилгаа болгон өгсөн боловч он дамжуулан 2006 онд тооцоо хийж зардалд бүртгэсэн нь СЭЗС-ын 2001 оны 188 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын гадаад арга хэмжээний зардлын төсөв зохиох, хянах, санхүүжүүлэх, тайлагнах журам”-ын гадаад оронд томилолтоор явагчид эх орондоо буцаж ирснээс хойш ажлын 7 өдөрт багтаан зардлын гүйцэтгэлийн тайланг гарган тооцоог хянуулна гэсэн заалтыг зөрчсөн байна.

2.18 Газрын даргын 2006 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 15 дугаар тушаалаар 2005 оны ажлын үр дүнгийн шагналд 85.7 сая төгрөг, 2006 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 25 дугаар тушаалаар ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 215.0 сая төгрөг, урьд нь ажиллагсдад олгосон зээлийг хөнгөлөхөд 38.0 сая төгрөг, УМХГ-ын актын төлбөрт 142.1 сая төгрөг, нийт 480.8 сая төгрөгийг агентлагт үлдэх орлогоос тооцон зарцуулжээ.

Яам хууль зөрчин харьяа агентлагийн төсвөөс 1.5 тэрбум төгрөг зарцуулжээ

2.19 ТБУСТХ-ийн 12 дугаар зүйлийн 3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын ерөнхий менежерт хуулиар олгогдсон эрх мэдлийг хязгаарлах буюу өөртөө шилжүүлэн авахыг хориглоно”, 14 дүгээр зүйлийн 1.5-д “Улсын төсвийн байгууллага энэ хуульд заасныг зөрчиж төсвөөс гадуур зардал гаргахыг хориглоно” гэсэн заалтуудыг ҮХЯ зөрчин АМГТХЭГ-аас 2005 онд 404.7 сая, 2006 онд 921.3 сая, 2007 оны эхний 9 сарын байдлаар 186.4 сая, нийт 1’512.4 сая төгрөгийг авч зарцуулсан байна. Тухайлбал:

- 2005 онд ҮХС-ын тушаал, яамны албан бичгийн дагуу албан томилолт, хүлээн авалтад 55.3 сая, ҮХЯ-ны барилгын өргөтгөл болон засварт 200.0 сая, Замын-Үүд, Алтанбулагийн чөлөөт бүсэд барилга худалдан авах, тэдгээрийг засвар үйлчилгээнд 52.5 сая, нийт 404.7 сая төгрөгийг;
- 2006 онд АМГТХЭГ-ын дансыг яаманд төвлөрүүлж, орлогын данснаас нийт 921.3 сая төгрөг зарцуулснаас 309.1 сая төгрөгийг бэлнээр;
- 2007 онд яамны гадаад томилолт, төвлөрсөн арга хэмжээ, гадаад зочны зардалд 186.4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

2.20 АМГТХЭГ-ын 2006 оны санхүүгийн тайланд “Координат-Аудит” ХХК аудит хийж, ҮХЯ-ны зарцуулсан 921.3 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардалд тусгах залруулга хийсэн боловч залруулгыг тусгаагүй байлаа.

2.21 ҮХЯ-ын төрийн нарийн бичгийн даргын 2006 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 123 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны шийдвэрээр АМГТХЭГ-ын хэрэгцээнд зориулан өгөгдлийн сангийн програм хангамжийг холбогдох компьютер, тоног төхөөрөмжтэй нь худалдан авах 61.2 сая төгрөгийн гэрээг ҮХЯ “Эм-Си-Эс электроникс” ХХК-тай 2006 оны 10 дугаар сард байгуулж, төлбөр хийжээ.

2.22 Гэтэл Эм Си Эс ХХК-ийн 2007 оны 1 дүгээр сарын 17-ны актаар хүлээлгэн өгсөн програм хангамжийг АМГТХЭГ-ын холбогдох мэргэжилтнүүд нэг процессортой серверийн орчинд ажиллахаар зориулагдсан лицензтэй, (АМГТХЭГ 2 сервертэй процессортой) 2002 онд бүтээгдсэн хуучин хувилбар учраас ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарган ашиглаагүй байна.

2.23 ҮХЯ ТБУСТХ-ийн 12 дугаар зүйлийн 1.5-д “ Эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцлийг хангах”, мөн зүйлийн 3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын ерөнхий менежерт хуулиар олгогдсон эрх мэдлийг хязгаарлах буюу өөрт авахыг хориглоно”, ЗГАЭЗБТХ-ийн

8.3.7-д “Агентлагийн төсвийг тогтоосон журмын дагуу захиран зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчин төсөвт байгууллагын дотоод ажилд хутгалдаж, АМГТХЭГ-ын захиалгыг авалгүй худалдан авалт хийснээс үргүй зардал гаргасан байна.

Их засварын зардлын төсвийг хэтрүүлжээ

2.24 АМГТХЭГ их засварын зардлын төсвийг 2005 онд 217.7 сая, 2006 онд 173.4 сая төгрөгөөр хэтрүүлжээ.

2.25 2006 онд ҮХС-ын шийдвэрээр орон тоо, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн тогтоож, шинээр нэмэгдсэн ажилтнуудад ажлын байр бэлтгэх зорилгоор тус газрын 2 дугаар байрыг лабораторийн зориулалтаар засварлах ажилд батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй 173.4 сая төгрөгийн зардал гаргажээ.

2.26 ҮХЯ-ны шийдвэрээр тоног төхөөрөмж, эд хогшил худалдан авахад 311.9 сая төгрөг зарцуулсан байна. Тоног төхөөрөмж, эд хогшлыг худалдан авахдаа “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 4-д “Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, захиалах, данснаас хасаж шилжүүлэх, устгах саналаа Төрийн өмчийн хороонд тавьж, энэ хуулиар тогтоосон журмын дагуу зөвшөөрөл авна” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Батлагдсан төсөвгүйгээр автомашин худалдан авчээ

2.27 АМГТХЭГ-ын 2007 оны төсөвт тоног төхөөрөмж худалдан авах зориулалтаар хөрөнгө батлагдаагүй боловч 773.6 сая төгрөгийн биет болон биет бус хөрөнгө бэлтгэсэн байна.

2.28 Төрийн өмчийн хорооны 2006 оны 10 дугаар сарын 12-ны 626 дугаар тогтоолоор АМГТХЭГ-ын албан ажлын хэрэгцээнд 7 автомашиныг 263.2 сая төгрөгт багтаан худалдан авахыг тус байгууллагын хүсэлтийг үндэслэн зөвшөөрчээ.

2.29 ҮХЯ “Албан хэрэгцээнд автомашин худалдан авах” 06/04 дугаартай тендер шалгаруулалтыг вэб хуудсаар зарлан явуулж, “Моннис интернэйшнл” ХХК, “Уулстрейд” ХХК, “Бодь Автмотив” ХХК үнийн саналаа ирүүлсэн байна.

2.30 ҮХС-ын 2006 оны 11 дүгээр сарын 218 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хороо “Моннис интернэйшнл” ХХК-тай гэрээ байгуулан, худалдан авалт хийх шийдвэр гаргажээ.

2.31 Гэтэл АМГТХЭГ тендер шалгаруулалтаар ялсан оролцогчтой дангаар нь бус “Уулс трейд” ХХК-тай хамтруулан Ланд круизер маркийн автомашин 2, Лексус маркийн автомашин 1, Ниссан урбан маркийн автомашин 1, Тоёото маркийн автомашин 1, нийт 5 автомашиныг 257.5 сая төгрөгөөр худалдан авах гэрээ байгуулж, төлбөрийг Монгол шуудан

банкин дахь үйлчилгээний орлогын 1100466470 дугаар данснаас “Моннис интернэйшнл” ХХК-ийн дансанд шилжүүлжээ.

2.32 ҮХС-ын 2007 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн 1 дүгээр тушаалаар дээрх автомашинуудыг худалдан авахад шаардагдах 257.5 сая төгрөгийг АМГТХЭГ-ын өөрт үлдэх орлогоос санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

2.33 Автомашины дээрх худалдан авалтыг хийхдээ Төрийн өмчийн хорооны 626 дугаар тогтоолыг бүрэн мөрдөөгүй байна.

Хүснэгт 2.5. Автомашин худалдан авалтын харьцуулалт

Төрийн өмчийн хороо зөвшөөрсөн нь:				ҮХЯ худалдан авсан нь:			
Автомашины нэр, загвар	Тоо	Худалдан авах үнийн дээд хязгаар /мян.төг/		Автомашины нэр, загвар	Тоо	Худалдан авсан үнэ /мян.төг/	
		Нэг бүр	Бүгд			Нэг бүр	Бүгд
Ланд круизер 100	3	54'990.0	16'4970.0	Ланд круизер	2	69'900.0	139'800.0
Микро автобус /Тоёото/	2	31'590.0	63'180.0	Лексус	1	55'920.0	55'920.0
Суудлын автомашин Соната	2	17'550.0	35'100.0	Тоёото микроавтобус	1	26'795.0	26'795.0
				Ниссан урбан	1	34'950.0	34'950.0
Нийт	7		263'250.0	Нийт	5		257'465.0

2.34 Дээрх худалдан авалтаас 5 хоногийн дараа ҮХС-ын тушаалаар “Моннис интернэйшнл” ХХК-иас дахин Ниссан маркийн 5 жип автомашиныг 337.2 сая төгрөгөөр худалдан авсан нь ТБУСТ, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг тус тус зөрчсөн үйлдэл болжээ.

2.35 “Моннис интернэйшнл” ХХК болон “Уулс трейд” ХХК-ийн хооронд 2006 оны 12 дугаар сарын 29-нд байгуулсан 06/12/26-27 дугаартай гэрээгээр ҮХЯ-нд нийлүүлсэн 10 автомашины зургааг нь буюу 342.2 сая төгрөгийн машиныг “Уулс трейд” ХХК, дөрвийг нь буюу 252.5 сая төгрөгийн автомашиныг “Моннис интернэйшнл” ХХК нийлүүлжээ.

2.36 Дээрх 10 автомашиныг хүлээн авсан акт АМГТХЭГ-т байхгүй бөгөөд “Моннис интернэйшнл” ХХК-ийн Ниссан маркийн 4 шинэ автомашиныг хүлээлгэн өгсөн баримтаас өөр шинэ автомашин авсан гэх баримт алга байлаа.

2.37 Татварын албанаас тодруулахад “Уулс трейд” ХХК нь 2007 онд НӨАТ-т 600.0 мянган төгрөг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 100.0 мянган төгрөг л төлсөн байгаа тул татварын дахин хяналтаар шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ

Сангийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү нарт :

- 2006 оноос өмнө газрын тосны салбарт хайгуул, олборлолтын чиглэлээр байгуулсан Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг одоо мөрдөж буй хуулиудад нийцүүлэн шинэчлэн байгуулах;
- Агентлагийн орлогыг улсын төсөвт бүрэн төвлөрүүлж, төсвөөс санхүүжилтийг олгох чиглэлээр Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3.5 дугаар заалтыг өөрчлөх санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
- ТБУСТ хуулийн 12.1.5, 12.3, ЗГАЭЗБТ хуулийн 8.3.7-д заасны дагуу агентлагийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах, ҮХЯ-наас шийдвэр гарган агентлагийн төсвөөс хөрөнгө зарцуулахыг зогсоох;
- Сургалтын санг Сургалтын төрийн санд нэгтгэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга Л.Болдод:

- Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96, 2004 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу шагнал, урамшил, нэмэгдлийг улирлын ажлын үр дүнгээр олгож, батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлэхгүй байх;
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан НББ-ийн дансны заавар, журмыг мөрдөж ажиллах.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР
Л.ЖАВЗМАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3. Утас: 26-36-28, Факс 31-03-70
E-mail: mram@magicnet.mn

2007.12.14 № 1-8625

танай _____-ны № _____-т

Аудитын тайлангийн төсөлд
өгөх санал хүргүүлэх тухай

УИХ-ын Төсвийн Байнгын хороо, Дорнод аймгийн Иргэдийн Төлөлөгчдийн хурлаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан Аудитын төлөвлөгөөний дагуу тус байгууллагын санхүүгийн зарим үйл ажиллагаанд 2007 оны 10 дугаар сарын 29-нөөс 11 дүгээр сарын 15-ны өдрүүдэд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцав.

Аудитын тайланд оруулах зарим өөрчлөлт, засварын талаар санал, үндэслэлийг хавсралтаар гарган хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.2 заалтын дагуу санал, хүсэлтийг тайланд тусгах арга хэмжээ авахыг хүсье.

Аудитын зөвлөмж болон Үндэсний Аудитын газраас өгөх албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн, биелэлтийг нь тайлагнах болно.

Аудитын тайлангийн төсөлд оруулах зарим өөрчлөлт, загварын талаарх тайлбар үндэслэлийг хавсаргав.



ДАРГА

Л.БОЛД



АМГТХЭГ-ын 2007 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 1/2007-14 тоотын хавсралт

УИХ-ЫН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО, ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛААС ИРҮҮЛСЭН ХҮСЭЛТ, МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН БАТАЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ АМГТХЭГ-ЫН САНХҮҮГИЙН ЗАРИМ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ОРУУЛАХ ЗАРИМ ӨӨРЧЛӨЛТ, ЗАСВАРЫН ТАЙЛБАР ҮНДЭСЛЭЛ

- Тайлбар 1-ийг үзнэ үү.
1. Тайлангийн төслийн Бүлэг 1.-ийн 1.5 дахь хэсгийн эцэст “Энэхүү журмыг 2005, 2006 оны санхүүгийн үр дүнг тооцоход мөрдөж байв” гэж нэмж оруулж өгөх.
- Тайлбар 2-ыг үзнэ үү.
2. АМГТХЭГ-ын орлого, түүний хувиарилалтын талаар хүснэгтийн 2007 оны эхний 9 сарын байдлаар орлогын төлөвлөгөөг анх баталсан хэмжээгээр тавьж орлого 1,6 дахин давж биелэн, уг газарт үлдэх орлогын хэмжээ ихэсчээ гэжээ.
- 2007 оны төсвийн тооцоог Төсвийн үе шатыг тогтоох тухай Засгийн газрын 2004 оны 73 дугаар тогтоолын дагуу 2006 оны 7 дугаар сард хийн Сангийн яаманд оруулан УИХ-аар батлуулсан.
- Тухайн үед 1 баррель газрын тосны үнэ 54 ам.долл орчим байсан ба 2007 он гараад газрын тосны үнэ огцом өсч 1 баррел нь 80 ам.долл хүртэл өсч байв.
- Энэ байдлыг харгалзан 2007 оны Төсвийн тодотголд оруулах тооцоог хийж Сангийн яаманд оруулсан ба УИХ төсвийн тодотголыг 2007 оны сүүлчээр батлан мөрдүүлээд байна.
- Тодотголын төлөвлөгөөгөөр тус агентлагаас 2007 онд улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг нэмэгдүүлэн 23,3 тэрбум төгрөгөөр баталсан болно.
- ҮХЯ-ны 2006 онд улсын төсөвт дутуу төлсөн 8463,4 сая төгрөгийн орлогыг 2007 оны эхэнд төсөвт төлсөн ба уг төлбөрийг оруулахгүйгээр агентлагаас 2007 оны төсвийн орлого 30 гаруй хувиар давж биелэх төлөвтэй байна.
- Иймд 1.7 дахь хэсгийг өөрчлөн найруулах.
- Тайлбар 3-ын үзнэ үү.
3. Сангийн сайд, Үйлдвэр худалдааны сайдын 2007 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 34/37 дугаар тушаалаар агентлагийн санхүүжилтийн талаар мөрдөж байсан журмыг хүчингүй болгосон билээ.
- Улсын төсвийн орлогоос тодорхой хувийг байгууллагын санхүүжилтийн эх үүсвэрт үлдээж байсан журмыг өөрчилж ашигт малтмалын тухай хуульд заасан тусгай зөвшөөрлийн төлбөр, улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөр болон газрын тосны экспортын орлогын Монгол Улсын

Засгийн газарт ногдох орлого зэрэг орлогыг 100 хувь төсөвт төвлөрүүлэх болсноос 2007 онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ 4,0 тэрбум гаруй төгрөгөөр нэмэгдэх боломж бүрдэж байгаа билээ.

Иймд 1.15 дахь заалт нь агентлагийн 2007 оны санхүүгийн үйл ажиллагаа, үр дүнд нийцэхгүй дүгнэлт гэж үзэж байна.

Тайлбар
4-ийг
үзнэ үү.

4. Сургалтын сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж байна.

Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 20 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын батламжилсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, олборлолтын ажлыг Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу гүйцэтгэж буй гадаад, дотоодын компаниудаас сургалтын урамшуулалд төвлөрүүлдэг хөрөнгийг Үйлдвэр, худалдааны сайдын 2003 оны 07 тоот тушаалаар батлагдсан журмын дагуу зарцуулж байгаа болно.

Тайлангийн төсөлд сургалтын сангийн хөрөнгийг сургалтын санд нэгтгэх нь зүйтэй гэж дүгнэлт гаргасан байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр ажиллаж буй гадаад, дотоодын компаниудаас төвлөрүүлэн авдаг сургалтын урамшуулал нь улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг сургалтын Төрийн сангийн хөрөнгөнөөс өөр, дараахь зүйлүүдээс ялгаатай юм.

1. АМГТХЭГ-ын гэрээлэгч компаниудаас БХГ-ний дагуу авдаг сургалтын урамшуулал нь сангийн хөрөнгө биш юм.

Засгийн газрын батамжилсан БХГ-нд заасны дагуу сургалтын арга хэмжээнд зарцуулагддаг хөрөнгө юм.

2. БХГ-нд уг урамшууллыг Гэрээлэгч АМГТХЭГ-т төлөхөөр заагдсан байдаг ба төлбөрийг ам.доллараар төлөхөөр заагдсан байдаг тул Төрийн санд шууд төвлөрүүлэх боломжгүй.

3. АМГТХЭГ-ын даргын 2007 оны 120 дугаар тушаалаар “Төрийн албан хаагчийн сургалт” хөтөлбөр болон Сургалтын журмыг шинэчлэн батлан хэрэгжүүлж байгаа болно.

Сургалтын хөтөлбөр журмын дагуу одоо БНХАУ, ОХУ, АНУ, Канад, ХБНГУ, Испани, Итали зэрэг орнуудад тус газрын нэр дээр 50 гаруй оюутан суралцаж байна.

Агентлагийн үйл ажиллагаа, хуулиар хүлээсэн чиг үүрэг, ажилтнуудын тоо нэмэгдэн улсын төсөвт агентлагаас төвлөрүүлдэг орлогын хэмжээ 2008 оны төлөвлөгөөгөөр 2004 оны хэмжээнээс 6,7 дахин өссөний дотор газрын тосны экспортын орлогоос Монгол Улсын Засгийн газарт ногдох хэмжээ 30 дахин өсөөд байна.

Газрын тосны олборлолтын хэмжээ огцом өсч газрын тос олборлогч орон болох хугацаа үүдэнд ирсэн энэ үед газрын тосны салбарт газрын тосны санхүү бүртгэл,

хууль, нарийн мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах, шаардлагатай мэргэжлээр сургалтанд цаг алдалгүй ажилтнуудаа хамруулах нь салбарын хөгжлийг хурдасгах гол нөхцөл гэдгийг анхааран ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Иймд энэ салбарын онцлог, шаардлагыг онцгойлон анхаарч газрын тосны хайгуул, олборлолтын ажлыг БХГ-ний зарчмаар хэрэгжүүлж буй нөхцөлд газрын тосны олон улсын салбар, ялангуяа газрын тос олборлож эхэлж буй орнуудын хувьд үндэсний мэргэжлийн боловсон хүчнээ бэлтгэдэг туршлагыг харгалзан үзэх шаардлагатай гэж үзэж байна.

Иймд БХГ-ний дагуу гэрээлэгч компаниудаас төвлөрүүлэн авдаг сургалтын урамшууллын хөрөнгийг Сургалтын төрийн санд нэгтгэх нь уул уурхай, газрын тосны салбарын хөгжилтэнд эерэгээр нөлөөлөхгүй, цаг үеэ олоогүй шийдэл болно гэдгийг анхааран зөвлөмжид тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

Тайлбар 5-ийг үзнэ үү. 5. Зөвлөмжийн Сангийн сайд, Үйлдвэр, худалдааны сайд нарт гэсэн хэсгийн 2006 оноос өмнө газрын тосны салбарт хайгуул, олборлолтын чиглэлээр байгуулсан Бүтээгшдэхүүн хуваах гэрээнүүдийг одоо мөрдөж буй хуулиудад нийцүүлэн шинэчлэн байгуулах, гэснийг шинэчлэх боломжийг судлах гэж өөрчлөх.

Тайлбар 6-ыг үзнэ үү. 6. Бүлэг.2. Зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлжээ. Шагнал урамшууллыг хавтгайруулан олгожээ. гэсний тухайд

Ашигт малтмалын тухай болон Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлага гарсантай холбогдуулан тус газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газарт оруулан 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар шийдвэрлүүлсэн болно.

Мөн Засгийн газрын 2007 оны 236 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоож 10 дугаар сарын 1-нээс мөрдүүлэх шийдвэр гаргасан болно.

Ийнхүү хуулийн хэрэгжилттэй холбогдон агентлагийн орон тоог нэмэгдүүлсэн, цалингийн хэмжээ нэмэгдсэн, төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ өссөн зэргийг харгалзан 2007 оны төсвийн тодотголоор агентлагаас улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ, үйл ажиллагааны зардлын хэмжээг Сангийн яамнаас хянаж УИХ-д оруулан баталсан билээ.

УИХ-ын баталсан 2007 оны тодотголсон төлөвлөгөөгөөр агентлагийн зардлын хэмжээг 2025193,0 мян.төгрөгөөр батлан зардлын гүйцэтгэлд нь Сангийн яамны Төрийн сангийн газраас хяналт тавин ажилаж байна.

Оны эхэнд ҮХЯ-ны худалдан авах үйл ажиллагааг нь зохион байгуулсан автомашин болон биет бус хөрөнгийн зардалд зарцуулсан 773,6 сая төгрөгийн зардлыг оруулахгүйгээр 2007 оны батлагдсан (төсвийн тодотголоор) төсвийг хэтрүүлэхгүйгээр ажиллах талаар холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласны дүнд батлагдсан төсөвт багтаан ажиллах нөхцлийг бүрдүүлээд байна.

Засгийн газрын шийдвэрийн дагуу ажилтнуудын албан тушаалын зэрэглэл, төрийн байгууллагад ажилласан хугацаанаа нь хамааруулан цалингийн сүлжлийг шинээр тогтоон мөрдүүлсэн, Үндэсний Аудитын газрын аудиторуудын шалгалтын явцад өгсөн зөвлөмж, чиглэлийг харгалзан агентлагийн даргын 2005 оны 46 дугаар тушаалаар баталсан журмын дагуу сар бүр олгож байсан урамшууллыг зогсоосон болно.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалт, тухайн үед Сангийн сайд, Үйлдвэр, худалдааны сайдын 2005 оны хамтарсан 15/11 дүгээр тушаалаар батлагдсан агентлагийн санхүүжилтийн зарчим, журмын хүрээнд дээрх урамшууллын талаар мөрдөж байсан журам нь зөрчигдөхгүй байсныг өмнөх шалтгалтуудын дүгнэлтээс харагдаж байсан болно.

**АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

АМГТХЭГ-аас ирүүлсэн саналд өгөх тайлбар

ҮАГ-ын тайлбар 1

Тайлбарыг хүлээн авч аудитын тайланд тусгав.

ҮАГ-ын тайлбар 2

Бид 2007 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар дүнг авч үзсэн бөгөөд аудитын явцад тайлант хугацааны төлөвлөлтөд өөрчлөлт орсон талаар ямар нэг нотлох зүйл байгаагүй.

ҮАГ-ын тайлбар 3

1.15-д 2005 он, 2006 он, 2007 оны эхний 3 улирлын орлогын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлд өгсөн дүгнэлт тул хэвээр үлдээлээ.

ҮАГ-ын тайлбар 4

Ашигт малтмал, газрын тосны мэргэжилтэн, боловсон хүчин бэлтгэх асуудал зөвхөн тухайн агентлагийн бус улс орны бодлогын чанартай асуудлын нэг болсон тул сургалтын төрийн санд нэгтгэх асуудлыг судалж үзэх нь зүйтэй гэж үзлээ.

ҮАГ-ын тайлбар 5

Бид аудитын дүн, дүгнэлтэд Бүтээгдэхүүн хуваах гэрээг одоо мөрдөгдөж буй хуулиудад нийцүүлэн шинэчлэн байгуулах нь зүйтэй гэж үзэж зөвлөмжид тусгасан болно.

ҮАГ-ын тайлбар 6

Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 96 тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчдад шагнал урамшил олгох журам"-ын 5 дахь заалтыг дагаж мөрдөөгүй, батлагдсан төсвөөс зардал хэтэрсэн тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2007 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23 дугаар зүйлийн 2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын санхүүгийн зарим үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр. Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасны дагуу аудитын явцад илэрсэн зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Х.Наранхүү, Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Ц.Шинэбаяр, Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга Л.Болд нарт хүргүүлсүгэй.

Дөрөв. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, түүний үр дүнг 2008 оны 6 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга Л.Болдод зөвлөсүгэй.


Тав. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хоёрдугаар газрын захирал О.Мэндбаярт даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

Монгол Улсын Ерөнхий аудиторын
2007 оны 6 дугаар тушаалын хавсралт



Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын санхүүгийн зарим үйл ажиллагаанд
хийсэн гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт

УХАО 127

/Ам.доллараар/

Байгууллагын нэр	Зөрчил хариуцагчийн		Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн	Тайлбар
	Нэр	Албан тушаал				
Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар	Л.Болд	Дарга	Сургалтын сангийн хөрөнгөөс зүй бусаар зарцуулсан төлбөрийг буцааж төвлөрүүлэх тухай	2	76.477	
	Д.Лхагвасүрэн	Ерөнхий нягтлан бодогч				
Дүн					76.477	

